



АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2025 I-IX

ГАРЧИГ

1. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ.....	1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл	1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	3
1.4. Газрын тосны салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого	3
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	4
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар	4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар	4
2.1.3. Газрын тосны салбар	4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн	7
3. ГАДААД ХУДАЛДАА.....	8
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	8
3.1.1. Уул уурхай, олборлох салбар	8
3.1.2. Газрын тосны салбар	9
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар	10
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт	10
3.2.1. Газрын тосны салбар	10

1. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025		Гүйцэтгэл хувь
			Төлөвлөгөө (Тод)	I-IX	
1	Нүүрс	мян.тн	85,000.0	62,616.8	73.7%
2	Зэсийн баяжмал	мян.тн	2,010.0	1,647.2	81.9%
3	Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	8,110.0	6,485.1	80.0%
4	Алт (Монголбанканд тушаасан) ¹	тн	17.0	9.8	57.8%
5	Газрын тос	мян.бар	4,248.9	2,679.4	63.1%
6	Цайрын баяжмал ²	мян.тн	150.0	114.6	76.4%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал ³	мян.тн	800.0	1,201.4	150.2%

Эх сурвалж: СЯ, ГЕГ, МБ

1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2025 оны эхний 9 сарын байдлаар 22,244.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 514.7 (2.3%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 5,771.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2,109.7 (26.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхай, олборлох 5,439.0 тэрбум төгрөг буюу 24.45 хувь;
- Газрын тос 200.1 тэрбум төгрөг буюу 0.90 хувь;
- ТЗ-ийн төлбөр 32.9 тэрбум төгрөг буюу 0.15 хувь;
- Бусад орлого 99.4 тэрбум төгрөг буюу 0.45 хувь.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 25.95 хувийг бүрдүүлж байна.

¹ Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.

² Цайр нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно

³ Хайлуур жонш нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

тэрбум төгрөг

Үзүүлэлт		2024	2025	Өөрчлөлт	
		I-IX		+/-	Хувь
Нийт орлогын дүн		7,881.1	5,439.0	-2,241.7	-29.2%
1	Алт	266.6	331.8	65.2	24.5%
2	Зэс	1,697.2	2,157.6	460.5	27.1%
3	Нүүрс	5,326.6	2,402.2	-2,924.4	-54.9%
4	Төмөр	105.8	177.8	72.1	68.1%
5	Цайр	61.6	105.2	43.6	70.8%
6	Хайлуур жонш	34.8	41.9	7.1	20.4%
7	Бусад	188.1	222.4	34.2	18.2%
8	Газрын тос	132.1	200.1	68.0	51.5%
9	Тусгай зөвшөөрлийн төлбөр	29.2	32.9	3.7	12.7%
10	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	1.4	1.7	0.3	22.2%
11	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Сонгон шалгаруулалтынШ-ын орлого/	35.3	95.0	59.7	2.7 ¹
12	Бусад орлого	2.4	2.7	0.3	12.8%

Эх сурвалж: СЯ, АМГТГ, УГА

Тайлбар: 1 – дахин их

1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2025 оны эхний 9 сарын байдлаар уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт 5,439.0 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Нүүрс 2,402.2 тэрбум төгрөг,
- Зэс 2,157.6 тэрбум төгрөг,
- Алт 331.8 тэрбум төгрөг,
- Төмөр 177.8 тэрбум төгрөг,
- Цайр 105.2 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 41.9 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 222.4 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 2,241.7 (29.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

- Зэс 460.5 (27.1%) тэрбум төгрөг,
- Төмөр 72.1 (68.1%) тэрбум төгрөг,
- Алт 65.2 (24.5%) тэрбум төгрөг,
- Цайр 43.6 (70.8%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 7.1 (20.4%) тэрбум төгрөг,
- Бусад 34.2 (18.2%) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Нүүрс 2,924.4 (54.9%) тэрбум төгрөг.

1.4. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2025 оны эхний 9 сарын байдлаар газрын тосны салбараас улсын төсөвт 200.1 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 68.0 (51.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

2025 оны эхний 9 сарын байдлаар 65,613.2 мян.тн нүүрс, 1,515.1 мян.тн зэсийн баяжмал, 3,845.1 тн молибдены баяжмал, 8,697.5 кг алт, 6,541.3 мян.тн төмрийн хүдэр, 2,926.1 мян.тн төмрийн баяжмал, 362.0 мян.тн хайлуур жоншны хүдэр, 178.6 мян.тн хайлуур жоншны баяжмал, 481.4 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал 411.4 (37.3%) мян.тн, төмрийн хүдэр 1,917.5 (41.5%) мян.тн, төмрийн хүдрийн баяжмал 321.1 (12.3%) мян.тн, хайлуур жоншны хүдэр 50.0 (16.0%) мян.тн, хайлуур жоншны баяжмал 73.8 (70.4%) мян.тн, цайрын баяжмал 82.4 (20.7%) мян.тн-оор тус тус өссөн байна.

Харин нүүрс 3,770.7 (5.4%) мян.тн, молибдены баяжмал 160.6 (4.0%) тн, алт 852.7 (8.9%) кг-аар тус тус буурсан байна.

2.1.2. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2025 оны эхний 9 сарын байдлаар 214.2 мян.тн нүүрсэн шахмал түлш, 5,734.5 тн катодын зэс, 25,981.1 тн металл бэлдэц, 24,373.0 тн металл цувимал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад катодын зэс 976.1 (20.5%) тн-оор өссөн байна.

Харин нүүрсэн шахмал түлш 101.9 (32.2%) мян.тн, металл бэлдэц 353.9 (1.3%) тн, металл цувимал 535.8 (2.2%) тн-оор тус тус буурсан байна.

2.1.3. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

2025 оны эхний 9 сарын байдлаар 2,817.6 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 337.1 (10.7%) мян.бар-иар буурсан байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2024		2025		Өөрчлөлт	
			IX	I-IX	IX	I-IX	(6-4)=?, (6/4)=%	
1	2		3	4	5	6	7	8
1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ								
1.1	Нүүрс	мян.тн	7,996.4	69,384.0	9,208.0	65,613.2	-3,770.7	-5.4%
1.2	Газрын тос	мян.бар	331.3	3,154.7	304.3	2,817.6	-337.1	-10.7%
1.3	Зэсийн баяжмал, ме/агуулгаар	мян.тн	137.0	1,103.7	171.2	1,515.1	411.4	37.3%
1.4	Молибдений баяжмал, ме/агуулгаар	тн	485.9	4,005.7	482.3	3,845.1	-160.6	-4.0%
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	1,375.2	9,550.2	1,524.9	8,697.5	-852.7	-8.9%
1.6	Төмрийн хүдэр, баяжмал:							
	Төмрийн хүдэр	мян.тн	487.9	4,623.9	1,047.8	6,541.3	1,917.5	41.5%
	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	401.6	2,605.1	513.3	2,926.1	321.1	12.3%
1.7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал:							
	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	52.5	312.0	48.1	362.0	50.0	16.0%
	Хайлуур жоншны баяжмал	мян.тн	7.9	104.8	31.7	178.6	73.8	70.4%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	50.8	399.0	57.3	481.4	82.4	20.7%
1.9	Мөнгөний баяжмал	тн	1,082.3	12,961.2	498.9	8,258.6	-4,702.6	-36.3%
2. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР								
2.1. Аж үйлдвэр								
2.1.1	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	47.9	316.1	25.3	214.2	-101.9	-32.2%
2.1.2	Катодын зэс	тн	748.2	4,758.4	584.8	5,734.5	976.1	20.5%
2.1.3	Металл бэлдэц	тн	3,022.9	26,335.0	3,324.2	25,981.1	-353.9	-1.3%
2.1.4	Металл цувимал	тн	3,051.0	24,908.8	3,060.0	24,373.0	-535.8	-2.2%

Эх сурвалж: УСХ

Тайлбар: 1 - дахин их

2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Салбар	тэрбум төгрөг					
	2024		2025		Өөрчлөлт	
	IX	I-IX	IX	I-IX	(5-3)=?, (5/3)=%	
1	2	3	4	5	6	7
Нийт дүн	3,510.4	31,895.1	4,076.8	30,734.4	-1,160.7	-3.6%
Уул уурхай, олборлолт	2,672.2	24,756.9	2,995.3	22,674.8	-2,082.1	-8.4%
Нүүрс олборлолт	1,513.3	15,408.5	1,278.1	10,425.3	-4,983.2	-32.3%
Газрын түүхий тос олборлолт	84.0	857.4	75.3	743.5	-113.9	-13.3%
Металлын хүдэр олборлолт	1,007.2	7,916.5	1,539.0	10,842.3	2,925.7	37.0%
Бусад ашигт малтмал олборлолт	33.1	278.8	59.0	390.9	112.1	40.2%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	34.5	295.7	44.0	273.0	-22.8	-7.7%
Боловсруулах үйлдвэр	680.7	5,522.1	874.5	5,945.3	423.1	7.7%
Үүнээс, Хүнд үйлдвэр	198.6	1,300.2	221.5	1,467.1	166.9	12.8%
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	27.1	162.4	15.8	112.0	-50.4	-31.0%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.7	3.9	0.6	5.6	1.8	45.4%
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.3	3.8	1.1	5.6	1.7	45.1%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	96.3	531.4	114.6	647.7	116.3	21.9%
Металл боловсруулах үйлдвэрлэл	48.8	365.8	55.7	425.2	59.3	16.2%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3.5	25.8	1.3	17.7	-8.0	-31.2%
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.6	5.1	0.6	4.4	-0.7	-13.4%
Бусад боловсруулах үйлдвэрлэл	21.2	201.9	31.8	248.8	46.9	23.2%

Эх сурвалж: YCX

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 9 сарын байдлаар 30.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (3.6%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 22.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 (8.4%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 5.0 (32.3%) их наяд төгрөг, газрын түүхий тосны олборлолт 113.9 (13.3%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Харин металлын хүдэр олборлолт 2.9 (37.0%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 73.8 хувийг эзэлж байна.

2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

Салбар	тэрбум төгрөг						
	2024		2025		Гад-д	Өөрчлөлт	
	IX	I-IX	IX	I-IX		(5-3)=+/-	(5/3)=%
1	2	3	4	5	6	7	8
Нийт дүн	4,149.9	38,359.5	5,727.4	40,077.1	28,033.6	1,717.6	4.5%
Уул уурхай, олборлолт	3,136.2	30,100.1	4,458.9	30,468.3	26,593.0	368.1	1.2%
Нүүрс олборлолт	1,644.9	17,806.1	1,531.2	10,786.2	10,007.0	-7,019.9	-39.4%
Газрын түүхий тос олборлолт	85.3	841.9	67.5	708.8	708.8	-133.2	-15.8%
Металлын хүдэр олборлолт	1,320.4	10,729.2	2,755.0	18,129.0	15,473.0	7,399.8	69.0%
Бусад ашигт малтмал олборлолт	50.2	399.9	67.5	463.1	404.2	63.2	15.8%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	35.4	323.0	37.8	381.2	-	58.2	18.0%
Боловсруулах үйлдвэр	855.6	6,636.7	1,059.6	7,490.2	1,440.6	853.5	12.9%
Үүнээс, хүнд үйлдвэр	212.5	1,432.7	254.8	1,859.6	504.8	426.9	29.8%
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.1	43.4	3.4	27.9	-	-15.5	-35.7%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.7	4.1	0.6	3.5	-	-0.6	-14.1%
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.4	9.9	3.2	9.0	-	-0.9	-9.3%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	124.3	712.4	140.8	805.2	-	92.8	13.0%
Металл боловсруулах үйлдвэрлэл	50.7	413.9	62.2	692.5	488.9	278.6	67.3%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5.1	30.6	5.4	33.5	15.9	2.9	9.5%
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.8	6.2	0.6	5.7	-	-0.55	-8.8%
Бусад боловсруулах үйлдвэрлэл	22.5	212.2	38.6	282.4	-	70.2	33.1%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны эхний 9 сарын байдлаар 40.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (4.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 368.1 (1.2%) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 7.4 (69.0%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

Харин нүүрс олборлолтын салбарын борлуулалт 7.0 (39.4%) их наяд төгрөг, газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 133.2 (15.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 28.0 их наяд төгрөг буюу 69.9 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 26.6 их наяд төгрөг буюу 94.9 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 19,242.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1,148.5 (5.6%) сая ам.доллараар буурсан байна. Экспорт импортоос 2,174.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 10,708.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1,074.1 (9.1%) сая ам.доллараар буурсан байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 10,096.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 952.0 (8.6%) сая ам.доллараар буурсан байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 94.3 хувийг эзэлж байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2024	2025	Өөрчлөлт	
		I-IX		+/-	%
Чулуун нүүрс	тн/ам.дол	112.5	67.2	-45.3	-40.2%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,908.7	2,394.8	486.1	25.5%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	81.8	71.8	-10.0	-12.2%
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,434.9	1,547.6	112.8	7.9%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	233.8	186.1	-47.7	-20.4%
Молибдены баяжмал	тн/ам.дол	15,666.8	16,161.6	494.8	3.2%
Алт	кг/ам.дол	74,495.4	103,466.8	28,971.5	38.9%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

3.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

Нүүрсний экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 4,064.4 сая ам.долларын 62,616.8 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2,672.3 (39.7%) сая ам.доллар буурсан ч, биет хэмжээгээр 1,391.6 (2.3%) мян.тн-оор өссөн байна. Нүүрсийг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 3,944.7 сая ам.долларын 1,647.2 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 1,680.2 (74.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 460.8 (38.8%) мян.тн-оор тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 465.5 сая ам.долларын 6,485.1 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 18.8 (4.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 1,023.7 (18.7%) мян.тн-оор тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 223.6 сая ам.долларын 1,201.4 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 8.8 (4.1%) сая ам.доллар, биет хэмжээгээр 282.6 (30.8%) мян.тн-оор тус тус өссөн байна. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын 87.9 хувийг Хятад, 11.7 хувийг Орос руу тус тус экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 177.4 сая ам.долларын 114.6 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 45.5 (34.5%) сая ам.доллар, биет хэмжээгээр 22.7 (24.7%) мян.тн-оор тус тус өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 64.5 сая ам.долларын 3,989.0 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2.8 (4.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 306.3 (7.1%) тн-оор буурсан байна. Молибдены баяжмалын 88.4 хувийг Хятад, 11.6 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Алтны экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 701.6 сая ам.долларын 6,780.8 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 31.1 (4.6%) сая ам.доллараар өсч, биет хэмжээгээр 2,220.0 (24.7%) кг-аар буурсан байна. Алтны 87.4 хувийг Швейцар, 12.1 хувийг Америк руу тус тус экспортолсон байна.

3.1.2. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Газрын тосны экспорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 200.0 сая ам.долларын 2,679.4 мян.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 48.9 (19.6%) сая ам.доллар, биет хэмжээгээр 420.4 (13.6%) мян.бар-иар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

3.1.3. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Катодын зэс: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 102.9 сая ам.долларын 11,205.1 тн катодын зэс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 21.8 (27.0%) сая ам.доллар, биет хэмжээгээр 2,033.5 (22.2%) тн-оор тус тус өссөн байна.

3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 8,533.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 74.4 (0.9%) сая ам.доллараар буурсан байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 1,775.9 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 59.2 (3.2%) сая ам.доллараар буурсан байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2024	2025	Өөрчлөлт	
		I-IX		+/-	%
Автобензин	тн/ам.дол	717.2	710.9	-6.4	-0.9%
Дизель түлш	тн/ам.дол	802.4	710.9	-91.6	-11.4%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

3.2.1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 87.3 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1,549.9 сая ам.долларын 2,103.0 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 72.8 (4.5%) сая ам.доллараар буурч, биет хэмжээгээр 86.3 (4.3%) мян.тн-оор өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 91.1 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 28.7 хувийг автобензин, 62.4 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 444.3 сая ам.долларын 625.0 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 19.7 (4.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 21.9 (3.4%) мян.тн-оор тус тус буурсан байна.

Дизель түлшний импорт: 2025 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 967.4 сая ам.долларын 1,360.9 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 20.8 (2.1%) сая ам.доллараар буурч, биет хэмжээгээр 129.4 (10.5%) мян.тн-оор өссөн байна.